



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

БИЗНЕСИЙН ТӨЛӨВИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

2026 оны II улирал

2026 оны 7 дугаар сар



I. ХУРААНГУЙ

“Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа”-ны мэдээллийг 2026 оны 6 дугаар сард цуглуулж, 401 аж ахуйн нэгжийн мэдээлэлд үндэслэн судалгааны үр дүнг нэгтгэлээ.

- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) хэлбэртэй, аж үйлдвэрийн салбарын тэр дундаа хүнсний болон хүнсний бус боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, 20-оос дээш жилийн туршлагатай, 200 хүртэл ажилтантай, 2.5 тэрбум төгрөгөөс дээш жилийн борлуулалтын орлоготой байна.
- Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдийн хариултаас хүлээгдэж буй инфляцыг тооцвол:

Аргачлал	2026 оны III улиралд	2027 оны II улиралд
Дундаж утгаар	10.9%	11.8%
Медиан утгаар	11.6%	12.4%


- 2026 оны I улиралд өсөх хандлага руу шилжээд байсан инфляцын хүлээлтийн утга энэ улиралд ахин нэмэгдлээ. Салбарын түвшинд харьцуулахад үйлчилгээний салбарын инфляцын хүлээлтийн утга ирэх улиралд 11.2%, ирэх 12 сард 12.1% буюу харьцангуй өндөр байв.
- **Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт:** 2026 оны II улиралд өмнөх улирлаас 15.1 нэгжээр нэмэгдэж, **96.1** утгатай буюу агшилтын мужид хэвээр хадгалагдлаа. Салбарын болон хэрэглэгчийн бүх үзүүлэлтүүд бага зэрэг сайжирсан нь эдийн засгийн идэвхжил, эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт сэргэж байгааг илэрхийлж байна.
- **Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт:** 2026 оны II улиралд **101.4** нэгжид хүрч өсөн тэлэлтийн мужид гарч, хөдөлмөрийн зах зээлийн талаарх хүлээлт сайжирчээ. Мөн өмнөх улиралтай харьцуулахад бүх салбарт ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт өссөн бөгөөд ялангуяа аж үйлдвэрийн салбарт хүлээлтийн үзүүлэлт огцом сэргэлт үзүүлжээ.
- **Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт:** 2026 оны II улиралд өмнөх улирлаас 12.1 нэгжээр буурч, **127.8** утгатай гарсан нь эдийн засгийн орчны талаарх тодорхой бус байдал өмнөх улиралтай харьцуулахад буурсныг илтгэж байна. Салбарын ангиллаар авч үзвэл, худалдаа, барилга болон үйлчилгээний салбаруудад тодорхой бус байдлын үзүүлэлт голлон буурав.
- Ирэх улирлын эрэлт, экспортын хүлээлтүүд өмнөх улирлаас өсөж, тэлэлтийн мужид шилжсэн нь аж ахуйн нэгжүүдийн дунд эдийн засгийн идэвхжил сэргэх хүлээлт давамгайлж байгааг харуулж байна. Ялангуяа аж үйлдвэр, дотоод худалдааны салбарын үзүүлэлт нэмэгдсэн нь нийт индекс сайжрахад голлон нөлөөлжээ.

II. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ


Судалгаанд хамрагдсан ААН-үүдээс үнийн ерөнхий түвшний өнгөрсөн үеийн өөрчлөлт болон цаашдын төлөвийн талаар асууж, үнийн мэдрэмжийн болон хүлээлтийн чиглэлийн индексийг тооцлоо. Судалгааны үр дүнгээр өнгөрсөн 3 болон 12 сарын үнийн мэдрэмжийн индексийн утга өмнөх улирлаас бага зэрэг нэмэгдэв. Өнгөрсөн 3 сарын үнийн мэдрэмжийн индекс 2026 оны I улиралд “инфляц одоогийн түвшнээс ихээр мэдрэгдсэн” мужид шилжсэн бөгөөд тайлант улиралд уг мужид хэвээр хадгалагдлаа. Харин өнгөрсөн 12 сарын үнийн мэдрэмжийн индекс сүүлийн 7 улирал дараалан “инфляц одоогийн түвшнээс ихээр мэдрэгдсэн мужид байна (Зураг 1).

2026 оны I улиралд инфляцын тухайн үеийн түвшин 7.4 хувь байсан нөхцөлд ААН-үүдийн ирэх 3 болон 12 сарын үнийн хүлээлтийг “одоогийнхоос нэмэгдэнэ”, “одоогийн түвшинд байна”, “одоогийнхоос буурна” гэсэн чанарын хариултаар үнэлэхэд чиглэлийн индексүүд мэдэгдэхүйц нэмэгдэж, “инфляц одоогийн түвшнээс их” мужид шилжсэн. Харин тайлант улиралд инфляцын тухайн үеийн түвшин 12 хувь болж нэмэгдсэн үед ижил аргачлалаар тооцсон ирэх 3 болон 12 сарын хүлээлтийн чиглэлийн индекс аль аль нь буурав. Үүний үр дүнд ирэх 3 сарын хүлээлтийн индекс “инфляц одоогийн түвшинд хэвээр” мужид шилжсэн бол ирэх 12 сарын хүлээлтийн индекс буурсан хэдий ч “инфляц одоогийн түвшнээс их” мужид хэвээр хадгалагдав (Зураг 2).

Зураг 1. Инфляцын мэдрэмжийн индекс



Зураг 2. Инфляцын хүлээлтийн индекс




Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа

ААН-үүдийн инфляцын хүлээлтийн тоон хариултад үндэслэн жигнэсэн дундаж утгыг тооцоход, 2026 оны III улирлын инфляцын хүлээлт өмнөх улирлаас 2.5 нэгж хувиар нэмэгдэж **10.9%**, 2027 оны II улирлын хүлээлт өмнөх улирлаас мөн 2.5 нэгж хувиар нэмэгдэж **11.8%**-тай гарлаа. Харин инфляцын хүлээлтийн тоон хариултын медиан¹ утгыг тооцоход, 2026 оны III улирлын инфляцын хүлээлт өмнөх улирлаас 3.3 нэгж хувиар өсөж **11.6%**, 2027 оны II улирлын хүлээлт 3.4 нэгж хувиар өсөж **12.4%**-тай байна (Зураг 3)

¹ Тоон асуулгын хариултаас [Nicholas J. Cox \(2009\)](#)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно.

Зураг 3. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга, медиан утгаар




Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа


Ирэх 3 сарын инфляцын хүлээлтийн тархалтаас харахад, 2026 оны I улиралд аж ахуйн нэгжүүдийн хүлээлт голчлон 7–9 хувийн интервалд төвлөрч байсан бол 2026 оны II улиралд 11–13 хувийн интервал руу шилжжээ. Тухайлбал, судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 60 гаруй хувь нь инфляцыг уг интервалд байна гэж хүлээсэн бөгөөд тархалтын оргил 11 хувьд хүрсэн байна. Тархалт ийнхүү баруун тийш шилжиж, харьцангуй өндөр түвшинд төвлөрсөн нь аж ахуйн нэгжүүдийн богино хугацааны инфляцын талаарх төсөөлөл өмнөх улирлаас мэдэгдэхүйц нэмэгдсэнийг харуулж байна. (Зураг 4).

Ирэх 12 сарын инфляцын хүлээлтийн тархалтад мөн адил баруун тийш чиглэсэн шилжилт ажиглагдав. Тухайлбал, 2026 оны I улиралд тархалтын оргил 7 хувьд төвлөрч, 9–11 хувийн хүлээлт харьцангуй түгээмэл байсан бол 2026 оны II улиралд тархалт 13 хувийн орчимд төвлөрч, 11–17 хувийн хүлээлтийн давтамж мэдэгдэхүйц нэмэгджээ. Энэ нь аж ахуйн нэгжүүдийн дунд хугацааны инфляцын хүлээлт өмнөх улирлаас нэмэгдэж, өндөр түвшинд шилжсэнийг илтгэж байна (Зураг 5).

Зураг 4. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, ирэх 3 сар



Зураг 5. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, ирэх 12 сар




Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа


Инфляцын хүлээлтийн утгыг салбарын ангиллаар авч үзвэл, 2026 оны I улиралд бүх салбарт нэмэгдээд байсан ирэх 3 сарын инфляцын хүлээлт тайлант улиралд мөн бүх салбарт багагүй нэмэгдэж, зорилтот түвшнээс давсан хэвээр байна. Тухайлбал, үйлчилгээний салбарын хүлээлт 11.2% буюу хамгийн өндөр түвшинд хүрсэн бол аж үйлдвэр, барилга болон худалдааны салбарын хүлээлт тус бүр 10.8%-тай гарлаа. Өмнөх улирлын үр дүнтэй харьцуулахад үйлчилгээний салбарын инфляцийн хүлээлт хамгийн их буюу 3.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Энэ нь богино хугацааны инфляцын талаарх хүлээлт бүх салбарт нэмэгдэж, өндөр түвшинд хүрсэнийг, ялангуяа үйлчилгээний салбарын аж ахуйн нэгжүүд үнийн өсөлтийг харьцангуй өндөр байхаар хүлээж байгааг харуулна (Зураг 6).

Ирэх 12 сарын инфляцын хүлээлт 2024 оны III улиралд хамгийн бага түвшинд хүрснээс хойш өсөх хандлагатай байна. Тус хүлээлт 2026 оны I улиралд бүх салбарт нэмэгдсэн бол тайлант улиралд өсөлт үргэлжилж, үйлчилгээний салбарт 12.1% буюу хамгийн өндөр түвшинд хүрлээ. Харин барилгын салбарын хүлээлт 11.9%, худалдааны салбарт 11.8%, аж үйлдвэрийн салбарынх 11.5%-тай гарчээ. Өмнөх улиралтай харьцуулахад үйлчилгээний салбарын инфляцийн хүлээлт хамгийн их буюу 3.1 нэгж хувиар өсжээ. Ийнхүү ирэх 12 сарын хүлээлт бүх салбарт ирэх 3 сарын хүлээлтээс өндөр байгаа нь аж ахуйн нэгжүүд инфляцын дарамт үргэлжилнэ гэж төсөөлж байгааг харуулна (Зураг 7).

Зураг 6. Инфляцын хүлээлтийн дундаж утга, салбараар (ирэх 3 сар)



Зураг 7. Инфляцын хүлээлтийн дундаж утга, салбараар (ирэх 12 сар)




Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа

Аж ахуйн нэгжийн хэмжээгээр² авч үзвэл, мөн ирэх 3 болон 12 сарын инфляцын хүлээлт 2024 оны III улиралд хамгийн бага түвшинд хүрсний дараа дахин өсөж, 2026 оны II улиралд багагүй хэмжээгээр нэмэгдлээ. Богино хугацааны буюу ирэх 3 сарын хүлээлтийн хувьд том бизнесийн хүлээлт 11.2% буюу хамгийн өндөр байгаа бол бичил бизнес 11.0%, дунд бизнес мөн адил 11.0%, жижиг бизнес 10.2%-тай гарчээ (Зураг 8). Түүнчлэн ирэх 12 сарын хүлээлтийн хувьд том болон бичил бизнесийн хүлээлт тус бүр 12.0% буюу хамгийн өндөр байгаа бол дунд бизнес 11.7%, жижиг бизнес 11.5%-тай гарчээ (Зураг 9).


² “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуульд тусгагдсан борлуулалтын орлогын зааг утгаар ангилав. Тодруулбал, жилийн 300 сая төгрөг хүртэл орлоготой бол “Бичил”, 300 саяас 1.0 тэрбум төгрөг хүртэл “Жижиг”, 1.0-2.5 тэрбум төгрөг бол “Дунд”, 2.5 тэрбум төгрөгөөс дээш бол “Том” ангилалд хамааруулав.

Өмнөх улиралд бичил болон жижиг аж ахуйн нэгжүүдийн инфляцын хүлээлт харьцангуй өндөр байсан бол тайлант улиралд том болон бичил аж ахуйн нэгжүүд ирэх улирлын болон жилийн дараах инфляцыг бусад ангиллын аж ахуйн нэгжүүдээс өндөр түвшинд хүлээжээ. Аж ахуйн нэгжийн хэмжээнээс үл хамааран инфляцын хүлээлт 11-12% орчимд буюу зорилтот түвшнээс өндөр хэвээр байна.

Зураг 8. Инфляцын хүлээлтийн дундаж утга, хэмжээгээр (ирэх 3 сар)




Зураг 9. Инфляцын хүлээлтийн дундаж утга, хэмжээгээр (ирэх 12 сар)




Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа

Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулсан хугацаагаар инфляцын хүлээлтийг авч үзвэл, ирэх 3 сарын хүлээлт 2026 оны I улиралд 8.3-8.5 хувийн түвшинд бүх бүлэгт ойролцоо байсан бол 2026 оны II улиралд 10.4-11.2 хувь болж, бүлэг тус бүрд өмнөх улирлаас 2 орчим нэгж хувиар нэмэгджээ. Үүнээс 20-оос дээш жил үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн богино хугацааны инфляцийн хүлээлт бусад бүлгээс хамгийн өндөр байна (Зураг 10). Ирэх 12 сарын инфляцын хүлээлтэд мөн ижил хандлага ажиглагдав. Тухайлбал, 2026 оны I улиралд бүх бүлэгт нэмэгдсэн инфляцын хүлээлт тайлант улиралд мөн өсөж, 11.3-12.2 хувийн түвшинд хүрсэн байна. Үүнээс 20-иос дээш жил үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн инфляцын хүлээлт мөн хамгийн өндөр түвшинд гарчээ (Зураг 11).

Зураг 10. Инфляцын хүлээлтийн дундаж утга, туршилагаар (ирэх 3 сар)



Зураг 11. Инфляцын хүлээлтийн дундаж утга, туршилагаар (ирэх 12 сар)



Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа


III. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт (ESI³)


Монгол Улсын эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт өмнөх улирлаас 15.1 нэгжээр нэмэгдсэн хэдий ч 2026 оны II улиралд **96.1** нэгжтэй гарснаар агшилтын мужид хэвээр хадгалагдлаа (Зураг 12). Ийнхүү өмнөх улиралд сүүлийн дөрвөн жилийн хамгийн доод түвшинд хүрээд байсан мэдрэмжийн үзүүлэлт энэ улиралд эргэн сэргэж 2025 оны турш хадгалагдсан өсөх чиг хандлагыг үргэлжлүүлээ. Салбарын индексүүдийг авч үзвэл аж үйлдвэрийн салбарын үзүүлэлт 109.1 утгатай гарснаар 8 улирлын дараа тэлэлтийн мужид шилжин орлоо. Харин бусад салбаруудын хувьд буюу хэрэглэгчийн бүлэг (98.3), барилга (87.3), дотоод худалдаа (82.5) , үйлчилгээ (80.8) зэрэг салбарын үзүүлэлт 100-аас доош буюу агшилтын мужид байна.

Өмнөх улиралтай харьцуулахад бүх салбарын үзүүлэлтүүд сайжирсан дүр зураг ажиглагдав. Тухайлбал, аж үйлдвэрийн салбарын индекс хамгийн их буюу 32.2 нэгжээр, дотоод худалдааны салбар 10.2 нэгжээр, барилгын салбар 8.7 нэгжээр, үйлчилгээний салбар 2.6 нэгжээр, хэрэглэгчийн мэдрэмжийн үзүүлэлт 2.2 нэгжээр тус тус нэмэгджээ (Зураг 13).

Зураг 12. Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт



Зураг 13. Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт, салбараар



Тэмдэглэл: Энэхүү үзүүлэлт нь эдийн засагт оролцогч талуудын (хэрэглэгч) өнгөрсөн 3 сарын шинэ захиалга, борлуулалт (санхүүгийн байдал, эдийн засгийн нөхцөл байдал), барааны нөөц, ирэх 3 сарын үйлдвэрлэл болон ажил эрхлэлт (санхүүгийн байдал, хэрэглээ, эдийн засгийн нөхцөл байдал) зэрэг үзүүлэлтүүдийн талаарх хүлээлтийн дунджаар тодорхойлогдох бөгөөд Евро комиссын “European Business Cycle Indicators” тайлангийн аргачлалд тулгуурлан тооцлоо. Үзүүлэлт 100-с дээш гарах нь эдийн засгийн нөхцөл байдал сайжрах, 100-с бага бол эдийн засгийн нөхцөл байдал муудах төлөвийг илэрхийлнэ.

Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт сайжирч байгааг илтгэх бөгөөд тус нийлмэл үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайлангийн аргачлалыг жишиг болгон аж үйлдвэр 40%, үйлчилгээ 30%, хэрэглэгч 20%, барилга 5%, дотоод худалдаа 5%-иар жигнэн тооцсон болно.

Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа


³ Economic Sentiment Index

Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт (EEI⁴)


Монгол улсын ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлаас 15.1 нэгжээр нэмэгдэж, 2026 оны II улиралд **101.4** утгатай гарснаар өмнөх улиралд агшилтын мужид шилжээд байсан мэдрэмжийн үзүүлэлт нэг улирлын дараа эргэн тэлэлтийн мужид шилжлээ (Зураг 14). Энэ нь өнгөрсөн улиралтай харьцуулахад аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөрийн зах зээлийн талаарх хүлээлт сайжирч буйг илэрхийлж байна.

Тус үзүүлэлтийг салбарын ангиллаар авч үзвэл, 2026 оны II улиралд өмнөх улирлаас бүх салбарын хувьд өссөн дүр зурагтай байв. Ялангуяа, 2026 оны I улиралд огцом буураад байсан аж үйлдвэрийн салбарын хүлээлт тайлант улиралд эрчимтэй сэргэж, тэлэлт, агшилтын зааг болох 100 нэгжийн орчимд хүрлээ. Түүнчлэн бусад салбарын ажил эрхлэлтийн хүлээлт мөн сайжирснаар хөдөлмөрийн зах зээлийн цаашдийн төлөвийн талаарх аж ахуйн нэгжүүдийн үнэлгээ нийт салбарт сэргэсэн дүр зураг ажиглагдлаа (Зураг 15).

Зураг 14. Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт



Зураг 15. Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт, салбараар



Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа

Эдийн засгийн тодорхой бус байдал (EUF⁵)

Монгол Улсын эдийн засгийн тодорхой бус байдлын талаарх аж ахуйн нэгж, иргэдийн үнэлгээнд үндэслэн тооцсон хүлээлтийн үзүүлэлт 2026 оны II улиралд өмнөх улирлаас 12.1 нэгжээр буурч, **127.8** утгатай гарлаа (Зураг 16). Өөрөөр хэлбэл, эдийн засгийн орчны талаарх тодорхой бус байдал өмнөх улирлаас бага зэрэг саарсныг харуулж байгаа боловч тус үзүүлэлт өндөр түвшинд хэвээр байна.


Салбарын ангиллаар авч үзвэл, 2026 оны I улиралд дотоод худалдаа, барилга болон үйлчилгээний салбарт мэдэгдэхүйц нэмэгдээд байсан эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт 2026 оны II улиралд 21.2-32.8 нэгжээр эргэж буурснаар нийлмэл үзүүлэлтийг буурууллаа. Харин аж үйлдвэрийн салбарын хувьд 2026 оны I улиралд бусад салбаруудын тодорхой бус байдлын үзүүлэлт ихээхэн муудаж байх үед дангаар бага зэрэг сайжирсан дүр зурагтай байсан тул энэ улиралд харьцангуй бага буюу 6.0 нэгжийн бууралт үзүүлжээ.

⁴ Employment Expectation Index


⁵ Economic Uncertainty Index

Хэрэглэгчийн бүлгийн үзүүлэлт төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд 153.2 утгатай буюу өндөр түвшинд хэвээр хадгалагдлаа (Зураг 17).

Зураг 16. Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт



Зураг 17. Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт, салбараар



Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа

IV. БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Ирэх улирлын эрэлтийн хүлээлт өмнөх улирлаас 19.4 нэгжээр өсөж, 109.1 утгад хүрснээр тэлэлтийн мужид шилжлээ. Салбарын ангиллаар авч үзвэл аж үйлдвэр болон дотоод худалдааны салбарын эрэлтийн хүлээлт хамгийн өндөр өсөлт үзүүлж тэлэлтийн мужид шилжсэн бол хэрэглэгчийн бүлгийн хувьд төдийлөн өсөлт үзүүлээгүй хэдий ч өмнөх улиралд харьцангуй өндөр түвшинд тэлэлтийн мужид байсан эрэлтийн хүлээлтийн үзүүлэлтийг хэвээр хадгаллаа. Ингэснээр нэг улирлын дараа эргэн тэлэлтийн мужид орсон бөгөөд аж ахуйн нэгжүүдийн дунд ирэх хугацаанд эрэлт мэдэгдэхүйц нэмэгдэх хүлээлт давамгайлж байна (Зураг 18). Мөн ирэх улирлын экспортын хүлээлт өмнөх улирлаас 3.1 нэгжээр өсөж, 99.8 утгатай буюу агшилтын мужид хэвээр хадгалагдсан ч 2024 оны IV улирлаас хойшхи хүлээлтийн утгуудтай харьцуулахад хамгийн эерэг утгатай байв. Салбарын түвшинд авч үзвэл өмнөх улиралд хамгийн өндөр бууралтыг үзүүлсэн дотоод худалдааны салбарын үзүүлэлт энэ улиралд эргэн сэргэж хамгийн ихээр өссөн нь нийт индекс бага зэрэг сайжрахад голлон нөлөөлжээ (Зураг 19).

Нөгөө талаас, зардлын дарамттай холбоотой хүлээлтүүд бага зэрэг буурав. Тодруулбал, ирэх улирлын ажиллах хүчний зардлын хүлээлт өмнөх улирлаас 3.3 нэгжээр буурсан боловч, 156.5 утгатай буюу өндөр түвшинд хэвээр хадгалагдав. Барилга болон үйлчилгээний салбарын ажиллах хүчний зардлын хүлээлт ихээхэн буурсан ч аж үйлдвэрийн салбарт эсрэгээр багагүй өссөн тул нийт индексийн өөрчлөлт бага гарлаа (Зураг 20). Түүнчлэн нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлаас 4.1 нэгжээр буурсан хэдий ч, 175.0 утгатай буюу өндөр түвшинд хадгалагдаж байгаа нь суурь өртөг нэмэгдсээр байгааг харуулна (Зураг 21).


Үүнээс гадна ирэх улирлын ханшийн хүлээлт өмнөх улирлаас 20.8 нэгжээр буурч, 136.2 утгатай буюу төгрөг сулрах мужид хэвээр хадгалагдсан бол зээлийн хүүний хүлээлт 12.2 нэгжээр буурч 123.1 утгатай зээлийн хүү өсөх мужид хэвээр гарлаа (Зураг 22, Зураг 23). Ерөнхийдөө, өмнөх улиралтай харьцуулахад эрэлтийн хүлээлт нэмэгдэж буйтай зэрэгцэн зардал, ханш болон санхүүжилтийн дарамтын хүлээлтүүд бага зэрэг буурч байгаа бөгөөд өмнөх улиралд сүүлийн

дөрвөн жилийн хамгийн сул түвшинд хүрээд байсан дийлэнх үзүүлэлтүүд энэ улиралд эргэн сайжирсан байна.


Зураг 18. Эрэлтийн хүлээлт




Зураг 19. Экспортын хүлээлт




Зураг 20. Ажиллах хүчний зардлын хүлээлт



Зураг 21. Нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлт



Зураг 22. Ханшийн хүлээлт



Зураг 23. Зээлийн хүүний хүлээлт



Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа

V. ХАВСРАЛТ 1: Аж ахуйн нэгжүүдийн ерөнхий мэдээлэл

Тус түүвэр судалгааг 2026 оны 6 дугаар сард аж ахуйн нэгжүүдийн дунд явуулж, нийт 401 аж ахуйн нэгж (ААН) хамрагдсан бөгөөд өмчлөлийн хэлбэрээр авч үзвэл 385 (96%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), 14 (3%) нь хувьцаат компани (ХК), үлдсэн 2 нь бусад төрлийн өмчлөлийн хэлбэртэй ААН-үүд байна (Хүснэгт 1).

Хувийн хэвшлийн ААН-үүд судалгаанд голлон хамрагдсан бөгөөд тэдгээрийн 50% нь 20-с дээш, 18% нь 15-20 жил, 16% нь 10-15 жил, 14% нь 5-10 жил, 1% нь 5 хүртэл жилийн турш үйл ажиллагаа эрхэлсэн ААН-үүд байна (Хүснэгт 2). Ерөнхий салбараар авч үзвэл аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын тус бүр 130 (32%), худалдааны салбарын 78 (19%), барилгын салбарын 63 (16%) ААН тус тус хамрагдлаа (Хүснэгт 3).

Жилийн борлуулалтын орлогын ангиллар авч үзвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой 182 (45%), 1.0-2.5 тэрбум төгрөгийн орлоготой 79 (20%), 300 саяас 1.0 тэрбум төгрөгийн орлоготой 68 (17%), 50.0-300.0 сая төгрөгийн орлоготой 56 (14%), 50 сая төгрөгөөс доош орлоготой 16 (4%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо (Хүснэгт 4).

Ажиллагсдын тооны ангиллаар харвал 10-49 ажилтантай 156 (39%), 1-9 ажилтантай 133 (33%), 50-200 хүртэл ажилтантай 75 (19%), 200-с дээш ажилтантай 37 (9%) аж ахуйн нэгжүүд судалгаанд хамрагдлаа (Хүснэгт 5).

Хүснэгт 1. Аж ахуйн нэгжийн тоо, өмчлөлийн хэлбэрээр

Өмчлөл	тоо	хувь
ХХК	385	96%
ХК	14	3%
Бусад	2	0%
Нийт	401	100%

Хүснэгт 2. Аж ахуйн нэгжийн тоо, туршилагаар (жил)

Туршилага	тоо	хувь
5 хүртэл	5	1%
5-10 хүртэл	57	14%
10-15 хүртэл	63	16%
15-20 хүртэл	74	18%
20-с дээш	202	50%
Нийт	401	100%

Хүснэгт 3. Аж ахуйн нэгжийн тоо, ерөнхий салбараар

Ерөнхий салбар	тоо	хувь
Аж үйлдвэр	130	32%
Барилга	63	16%
Дотоод худалдаа	78	19%
Үйлчилгээ	130	32%
Нийт	401	100%

Хүснэгт 4. Аж ахуйн нэгжийн тоо, орлогоор

Борлуулалтын орлого	тоо	хувь
50 сая₮ хүртэл	16	4%
50-300 сая₮ хүртэл	56	14%
300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	68	17%
1-2.5 тэрбум₮ хүртэл	79	20%
2.5 тэрбум₮ дээш	182	45%
Нийт	401	100%

Хүснэгт 5. Аж ахуйн нэгжийн тоо, ажиллагсдын тоогоор

Ажиллагсдын тоо	тоо	хувь
1-9	133	33%
10-49	156	39%
50-200	75	19%
200-с дээш	37	9%
Нийт	401	100%

Хүснэгт 6. Аж ахуйн нэгжийн тоо, хэмжээний ангилал

Хэмжээний ангилал	тоо	хувь
Бичил	72	18%
Жижиг	68	17%
Дунд	79	20%
Том	182	45%
Нийт	401	100%

VI. ХАВСРАЛТ 2: Аргачлалын тайлбар

Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт (ESI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт нь аж ахуйн нэгжийн болон хэрэглэгчдийн түүвэр судалгаанд хамрагдсан таван үндсэн салбарын аж ахуйн нэгж, хэрэглэгчдээс сонгогдсон асуултуудад өгсөн хариултуудын жигнэсэн дундаж үзүүлэлт юм. Аж үйлдвэр (жин 40%), үйлчилгээ (30%), хэрэглэгчид (20%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (5%), барилгын салбарууд (5%) хамаарна. Аж үйлдвэрийн салбараас тухайн улирлын **шинэ захиалга, бэлэн бүтээгдэхүүний нөөц**, ирэх улирлын **үйлдвэрлэл**, барилгын салбараас тухайн улирлын **шинэ захиалга**, ирэх улирлын **ажил эрхлэлт**, дотоод худалдааны салбараас тухайн улирлын **борлуулалтын орлого, худалдан борлуулах барааны нөөц**, ирэх улирлын **борлуулалтын орлого**, үйлчилгээний салбараас тухайн улирлын **бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдал, шинэ захиалга**, ирэх улирлын **борлуулалтын орлого**, хэрэглэгчдээс тухайн улирлын **санхүүгийн байдал**, ирэх улирлын **санхүүгийн байдал, хэрэглээ** болон **эдийн засгийн нөхцөл байдал** зэрэг үзүүлэлтүүдийг асууж, асуулт тус бүрийн эерэг сөрөг хариултуудын нийт хариултад эзлэх хувийн зөрүүгээр тодорхойлсон болно.

Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт (EEI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Ажлын эрхлэлтийн хүлээлтийн индекс нь судалгаанд хамрагдсан дөрвөн үндсэн салбарын аж ахуйн нэгжүүдийн хүлээлтийн жигнэсэн дунджаар тооцогдоно. Аж үйлдвэр (жин 23%), барилга (8%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (18%), үйлчилгээний салбарууд (51%) хамаарна. ААН-үүдээс **ирэх улирлын ажил эрхлэлт** хүлээлтийн өөрчлөлтийг судалж, “Өснө”, “Буурна”, “Мэдэхгүй”, “Хэвэндээ” гэсэн дөрвөн хариултын эерэг/сөрөг балансаар тодорхойлсон болно.

Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт (EUI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Ажлын эрхлэлтийн хүлээлтийн индекс нь аж ахуйн нэгжийн түүвэр судалгаанд хамрагдсан таван үндсэн салбарын өгсөн хариултуудын жигнэсэн дунджаар тооцогдоно. Аж үйлдвэр (жин 40%), барилга (5%), хэрэглэгчид (20%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (5%), үйлчилгээний салбарууд (30%) хамаарна. ААН-үүдээс **өнгөрсөн улирлын тодорхой бус байдлын** талаарх өөрчлөлтийг судалж, “Өссөн”, “Буурсан”, “Мэдэхгүй”, “Хэвэндээ” гэсэн дөрвөн хариултын эерэг/сөрөг балансаар тодорхойлсон болно.

Медиан утга (Symmetric Linear Interpolated Median)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо тоон асуулгын хариултаас Nicholas J. Cox (2009)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно. Хүлээлтийн утгыг тооцохдоо ХҮИ-д тулгуурлаж байгаа тул үнийн ерөнхий хандлагыг харуулна. Энэхүү тооцсон хүлээлтийн утга нь инфляцын утгыг шууд илэрхийлэхгүй болно.